БАРИЛГЫН САЛБАРЫН 99 ЖИЛИЙН ОЙД
ЗОРИУЛАН БЭЛТГЭВ



МБҮА

Зөв зүгт
Манлайлна

ИХ БАРИЛГА -99

Сонирхолтой...

Хэрэгтэй ...

УЛААНБААТАР ХОТ
2025

БАРИЛГЫН САЛБАРЫН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ТОЙМ

Ардын хувьсгал ялж, 1924 онд анхны үндсэн хуулиа баталж Монгол улсыг Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэмээн нэрлэж, Улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрийдэн эдэлбэр газрыг нь 104 га байхаар тогтож, Хиагт, Ховд, Улиастай зэрэг сууринуудыг Монгол Улсын хот болгож, томоохон 115 хүрээ сууринд аймаг сумын засаг захиргаа, соёлын асуудлыг төвлөрүүлэх тогтоол гаргасан нь дэлхийн соёл иргэншлийн нэг хэлбэр суурьшмал хот суурин байгуулах үзэл баримтлалын анхны үр хөврөл, хууль эрх зүйн баримт бичиг болж түүхэнд үлдсэн билээ.

Ардын Засгийн газраас 1926 онд барилгын хоршоо байгуулж, түүний харьяанд зураг төслийн групп байгуулж, гар бааюу бүхий тоосгоны дөрвөн завод, шохой шатаах хэд хэдэн бааюу, бас альбастрын үйлдвэр ашиглалтад оруулжээ.

Энэ үед Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн 1921, 1925 оны программууд болон улс орныг үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажил ид өрнөж улмаар Цэнгэлдэх хүрээлэн, Хараагийн спирт завод, Цагаанбулагийн шохойн завод, Улаанбаатар цахилгаан станц, Үйлдвэрчний төв зөвлөлийн байшин, Улаанбаатарын арьс ширний завод, Аж үйлдвэрийн комбинат, Хатгалын ноос угаас фабрик, Налайхын нүүрсний уурхай зэрэг байгууламжуудыг барьсан байна.

Төв банк, Дотоодыг хамгаалах яам, Кино үйлдвэрийн барилга, аж үйлдвэрийн комбинат, төв цахилгаан станц, ноос угаах үйлдвэр, Хөдөө аж ахуйн яам, Радиогийн хэрэг эрхлэх хороо, зэрэг өөр хоорондоо зохицоогүй эрс тэс ялгаатай элементүүдээс бүрдсэн барилга байгууламж бүхий социалист системийн хот суурины барилгажилтын эхлэл тавигдсан. Үүнийг дагаад Нийслэл хүрээ, Хиагт, Ховд, Улиастай зэрэг хот сууринд хүн ам ч эрс нэмэгджээ. Урьд өдөр нь мал маллаж байсан монгол хүн гэнэт барилга барих болсон нь барилгын ажлын мэдлэг, туршлага дутагдахын зэрэгцээ ялангуяа барилгын материал, багаж хэрэгсэл барилгын техник, машин механизм байхгүй зэрэг хүндрэлтэй тулгарчээ. Тэр үед барилгын материалыг тэмээ, морь зэрэг ердийн хөсгөөр тээвэрлэж байв. Өөр нэг асуудал нь барилга барихад тооцох газар хөдлөл, усан хайгуул, геологи, орон нутгийн барилгын материал, барилгын уур амьсгал, цаг, агаарыг судлах явдал байв. Ийнхүү үндэсний аж үйлдвэрийн суурь тавигдаж үндэсний ажилчин анги анх үүсэн бий болж тэдний нийгмийн асуудлыг шийдэх зайлшгүй зорилт гарч иржээ.

Манай улс барилга, байгууламж тоног төхөөрөмжийн тооллогыг 1926, 1927, 1930 онд хүн ам, малын тооллоготой хамт явуулж байжээ. Хошуу, жасын үл хөдлөх хөрөнгийн 1926 оны тооллогоор 30 гаруй мянган орон байшин тоологдсон байна.

Монголын хувь нийлүүлсэн барилгын хоршоо, хувь нийлүүлсэн “Монгол транс” нийгэмлэгийн харьяанд 1926 онд зам, барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий газар, мал аж ахуйн яамны дэргэд 1929 онд худаг усны хайгуул, барилгын ажлыг эрхэлсэн усан хангамжийн салбар, аж үйлдвэр, барилгын яамны харьяанд 1938 онд барилгын үйлдвэрлэлийг эрхлэн гүйцэтгэх трест, мөн аж ахуйн аргаар барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчийн газар 1937 онд байгуулагдсанаар эдгээр салбарт барилгын статистикийн нэгж бий болсон байна. Энэ үеэс барилгын салбарын бүтээн байгуулалтын талаарх тоон түүх албан ёсоор бичигдэж эхэлжээ.

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Энэхүү судалгааг бэлтгэхэд Үндэсний статистикийн хорооноос гаргасан албан ёсны статистикийн мэдээллийг эх үүсвэр болгон ашиглав.

АГУУЛГА

ХЭСЭГ 1. 2020-2024
- Барилгын салбарын мэдээллийн 2020-2024 оны гүйцэтгэл

ХЭСЭГ 2. ТҮҮХЭН МЭДЭЭЛЭЛ
- Барилгын салбарын мэдээллийн 1948-1992 оны гүйцэтгэл

СУДАЛГААГ ХЯНАСАН:
Г. Батсүх, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал
М. Энхбаатар, МБҮА ТББ-ын Ажлын албаны СБТСХ-ийн дарга


СУДАЛГААГ БЭЛТГЭСЭН:
Б. Саранчимэг, МБҮА ТББ-ын Ажлын албаны СБТСХ-ийн судалгааны менежер

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
Монгол Улс, Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, МН Тауэр, 8 дугаар давхар, 805, 806, 811
Утас: 976-7011-1515
Цахим хуудас: www.mnca.mn
И-мэйл: research@mnca.mn


БАРИЛГЫН САЛБАРААС ТӨРСӨН АЛДАРТНУУД



МБҮА ТББ-ААС ТӨРСӨН АЛДАРТНУУД



МБҮА ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГУРВАН ТУЛГУУР



ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН БАЙДАЛ

Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-нд **“ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”**

Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг –ийн **“УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”**

ДОТООДОД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН БАЙДАЛ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын **“САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭНТРЕПРЕНЁР”**


Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын **“ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН”**

“НОГООН БАРИЛГЫН ХҮРЭЭЛЭН” ТББ-ын **“УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”**


Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны МОНГОЛЫН АНХНЫ **“ААА” ЗЭРЭГЛЭЛИЙН** ТББ

ХЭСЭГ 1: 2020-2024


Барилгын салбарт 2024 онд 18.3 мянган ААНБ бүртгэлтэй байгаагаас 8.6 (46.9%) мянган ААНБ нь үйл ажиллагаа явуулж байна.




2024 онд барилгын нийт 93.2 мянган ажиллагчдын 44.1 хувь нь 15-34 насны, 49.6 хувь нь 35-54 насныхан байна.



Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин улсын хэмжээнд 2024 онд 2.2 сая төгрөг байна.



Барилгын салбарын нэг ажиллагчид ногдох бодит ДНБ, 2024 онд 11.0 сая төгрөг болж, өмнөх оноос 0.3 (2.2%) сая төгрөгөөр буурчээ.




Барилгын салбарын ажиллагчдын 77.2 хувь нь Улаанбаатар хотод, 7.3 хувь нь төвийн бүсэд, үлдсэн 15.6 хувь нь Баруун, Хангайн болон Зүүн бүсэд ажиллаж байна.



Эх үүсвэр: 1212.mn


ХЭСЭГ 1: 2020-2024




Барилгын салбарт 2024 онд 37.9 мянган хүн албан бус хөдөлмөр эрхэлж байсны 82.3 хувь нь эрэгтэйчүүд, 17.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

2024 онд 892 хүн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсаны 27 нь барилгын ажилд зуучлагджээ.

Гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүний тоо, 2020-2024




Барилгын салбар нь нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 3.9 хувийг эзэлж байна.



2024 онд манай улсын эдийн засгийн өсөлт 4.9 хувь болсон байна.



2024 онд 1.9 (6.1%) их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт барилгын салбарт хийгдсэн нь өмнөх оноос 421.5 (28.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.



Эх үүсвэр: 1212.mn

ХЭСЭГ 1: 2020-2024

Барилгын зах зээлийн багтаамж, 2024 оны эцсийн байдлаар




Барилгын зах зээлийн багтаамж, төрлөөр, 2024



88.0 хувь буюу 8.1 их наяд төгрөгийн ажлыг хувийн хэвшлийн барилгын байгууллагууд гүйцэтгэжээ.


Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчээр




Эх үүсвэр: www.1212.mn

Барилгын салбарын ДНБ-ий цэвэр өсөлт 2024 онд 10.4 хувьд хүрсэн байна.


Барилгын дотоодын нийт бүтээгдэхүүний цэвэр өсөлт, 2020-2024



Ашиглалтад оруулсан барилга, хүчин чадлаар, 2024




Ашиглалтад оруулсан орон сууцны барилгын ажлын өртөг 2024 онд 3.0 их наяд төгрөг болж, нийт 19.8 мянган айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 594 айлаар өссөн байна




ХЭСЭГ 1: 2020-2024

Улсын хэмжээнд 19.8 мянган айлын орон сууц ашиглалтад орсны 15.0 (75.5%) мянга нь Улаанбаатар хотод, 4.8 (24.5%) мянга нь орон нутагт байна.



Ипотекийн зээлд шинээр хамрагдсан иргэдийн тоо 2024 онд 21.2 мянга болж, өмнөх оноос 4.5 (26.6%) мянган иргэнээр өссөн байна.



Эх үүсвэр: Монголын ипотекийн корпорацын 2024 оны тайлан

Улсын хэмжээнд 2024 онд 30.3 мянган суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан бөгөөд үүний 12.2 (40.4%) мянга нь Улаанбаатар хотод, 18.1 (59.6%) мянга нь аймгуудад байна.



Дархан-Уул аймагт 3480 суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан нь аймгуудын хэмжээнд хамгийн их, Сэлэнгэ аймагт 200 суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Улсын хэмжээнд нийт 1104 ортой эмнэлгийн барилга ашиглалтад оруулсан боловч орны тоо өмнөх оноос 107 (8.8%) -оор буурсан байна.




Дорнод аймагт 405 ортой, Улаанбаатар хотод 286 ортой, Дархан-Уул аймагт 118 ортой, Хэнтий аймагт 70 ортой эмнэлгийн барилгууд ашиглалтад орсон байна.

Улсын хэмжээнд нийт 817.6 км авто замыг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд энэ нь 2023 оноос 106.4 (15.0%) км-ээр нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2024 онд 3361.6 метр гүүр, гүүрэн гарцыг шинээр ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 1634.6 (94.6%) метрээр нэмэгдсэн байна. Улаанбаатар хотод 3104.9 метр гүүр, гүүрэн гарц ашиглалтад оруулжээ.

ХЭСЭГ 1: 2020-2024

Барилгын зарим нэр төрлийн материалын үйлдвэрлэл, импорт, 2024




Барилгын зарим нэр төрлийн материалын үйлдвэрлэл, импорт, 2024



Барилгын зарим нэр төрлийн материалын үйлдвэрлэл, импорт, 2024



Барилгын зарим нэр төрлийн барааны жилийн дундаж үнэ, төгрөг




2024 оны эцэст шинэ орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 4653 мянган төгрөг, хуучин орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 4266 мянган төгрөг




ХЭСЭГ 2: ТҮҮХЭН МЭДЭЭЛЭЛ

Барилгын ажилчин, албан хаагчдын дундаж тоо, мянган хүн



1940 онд 14.1 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж байсан бол 10 жилийн дараа 2.3 дахин нэмэгджээ.


Барилга угсралтын ажил, сая төгрөгөөр, 1940-1992



Ашиглалтанд оруулсан орон сууц, мянган кв.м, 1956-1992



Улс ардын аж ахуйн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ, сая төгрөг



Үйлдвэрлэсэн цемент, мян.т, 1970-1992

1970 онд 96.2 мянган тонн цемент үйлдвэрлэж байсан бол энэ үзүүлэлт 1987 онд 5.6 дахин нэмэгдсэн нь 1970-1992 оны хооронд цементийн үйлдвэрлэлийн хамгийн оргил үе байжээ.



Тоосго, шохой үйлдвэрлэл, биет хэмжээгээр, 1950-1992

1988 онд 180.6 сая ширхэг тоосго, 122.2 мянган тонн шохой үйлдвэрлэж байсан нь 1950-1992 оны хооронд үйлдвэрлэлийн хамгийн оргил үе байжээ.

